СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2025 X

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



www.sukhbaatar.nso.mn

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025
10 сар

Баруун-Урт сум

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:
  АС Асгат
  БД Баяндэлгэр
  ДА Дарьганга
  МХ Мөнххаан
  НА Наран
  ОН Онгон
  СҮ Сүхбаатар
  ТШ Түвшинширээ
  ТЦ Түмэнцогт
  УБ Уулбаян
  ХА Халзан
  ЭЦ Эрдэнэцагаан
  БУ Баруун-Урт
- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

... Мэдээлэл байхгүй
0.0 Маш бага тоо
¹ Дахин
a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь өөрчлөлт
\- Гүйцэтгэл байхгүй
* Урьдчилсан гүйцэтгэл

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамааарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл	2
	Үндсэн үзүүлэлтүүд	4
I	Хүн ам	5
II	Хөдөлмөр	6
III	Нийгмийн халамж	7
IV	Эрүүл мэнд	9
V	Гэмт хэрэг	11
VI	Мөнгө, банк	12
VII	Орон нутгийн төсөв	13
VIII	Үнэ	14
IX	Хөдөө аж ахуй	18
X	Аж үйлдвэр	19
XI	Барилга	23
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	25
	Хавсралт хүснэгтүүд	27

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Сар			Өөрчлөлт	
		2022	2023	2024	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Дүн	Хувь
ХӨДӨЛМӨР									
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	363	302	234	96	165	232	67	40.6
НИЙГМИЙН ХАЛАМЖ									
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон дүн	сая.төг	11 093.1	13 019.8	16 461.7	10 711.0	13 642.2	15 633.1	1 990.9	14.6
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	хүн	27 369	29 221	29 423	25 931	27 673	22 419	-5 254	- 19.0
ЭРҮҮЛ МЭНД									
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 110	1 213	955	1 014	825	693	- 132	- 16.0
Амаржсан эх	хүн	1 112	1 209	949	1 010	819	693	- 126	- 15.4
Нас баралт	хүн	294	298	336	248	284	263	- 21	- 7.4
1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	9	6	7	4	7	8	-	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	хүн	4	5	3	5	3	1	- 2	- 66.7
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	5 369	924	617	817	532	691	159	29.9
ГЭМТ ХЭРЭГ									
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	511	456	497	397	419	571	152	36.3
Хэрэгт холбогсод	хүн	409	328	343	238	251	339	88	35.1
МӨНГӨ, БАНК									
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	133.9	145.2	175.5	137.5	165.7	170.4	4.7	2.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	191.6	232.1	307.6	238.0	305.2	334.8	29.6	9.7
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ									
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	62.9	82.8	103.3	61.1	79.7	75.9	- 3.8	- 4.8
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	52.0	64.5	83.8	49.5	57.5	74.6	17.1	29.7
ҮНЭ									
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	12.7	7.1	7.6	5.6	5.2	4.2	- 1.0	-
АЖ ҮЙЛДВЭР									
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	149.8	221.3	299.9	177.3	235.6	380.0	144.4	61.3
Борлуулсан бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	322.8	432.1	447.7	375.0	365.0	481.5	116.5	31.9
ГАЗАР ТАРИАЛАН									
Хураасан ургац: -Үр тариа	тн	3 478.0	2 865.0	2 395.0	2 535.0	2 395.0	2 798.0	403.0	16.8
- Төмс	тн	585.9	612.7	531.9	609.4	529.3	433.3	- 96.0	- 18.1
-Хүнсний ногоо	тн	872.2	1 060.6	569.2	1 034.9	561.7	568.7	7.0	1.2
- Тэжээлийн ургамал	тн	1 768.0	2 407.5	2 987.5	2 343.5	2 742.5	1 710.5	-1 032.0	- 37.6
-Техникийн ургамал	тн	810.0	1 120.0	173.6	645.0	1 120.0	943.0	- 177.0	- 15.8
Ургац хураалт, хадлан: Өвс	тн	18 117.8	33 736.1	37 321.3	15 532.3	14 093.2	15 526.8	1 433.6	10.2

Тайлбар: ** дахин

ХҮН АМ

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 16.0 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээллээр 2025 оны эхний 10 дугаар сард 693 эх амаржиж, 693 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 126 (15.4%)-аар, төрсөн хүүхэд 132 (16.0%)-өөр тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар



2025 оны эхний 10 дугаар сард нас баралт 263 болж, өмнөх оны мөн үеэс 21 (7.4%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 10.5, нас баралт 4.0, ердийн цэвэр өсөлт 6.5 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оны мөн үеэс 0.3 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 40.6 хувиар өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 10 дугаар сарын эцэст 232 болсны 102 (43.9%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 67 (40.6%) хүнээр өсж, 2024 оны 12 дугаар сараас 2 (0.9%) хүнээр буурсан байна.
2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1383 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 669 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар**



Ажилгүй иргэдийн 163 (70.3%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.
Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 33 (14.2%) нь бакалавр, 7 (3.0%) нь тусгай мэргэжлийн дунд, 12 (5.2%) нь мэргэжлийн анхан шат, 103 (44.4%) нь бүрэн дунд, 58 (25.0%) нь суурь, 14 (6.0%) нь бага, 5 (2.2%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 2025 оны 10 дугаар сарын эцэст**



Ойлголт, тодорхойлолт:
Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.
Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнөх оноос 1.2 (1.5%) сая төгрөгөөр өслөө.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 оны эхний 10 дугаар сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.5 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 24 (1.6%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 5.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.7 (13.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 оны эхний 10 дугаар сард 3.1 мянган хүн хамрагдсаны 50.1 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.9 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

2025 оны эхний 10 дугаар сард нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 15.6 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 2.0 (14.6%) тэрбум төгрөгөөр өсөж, 22.4 мянган хүн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 5.3 (19.0%) мянган хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	2023 I-X		2024 I-X		2025 I-X		Өөрчлөлт	
							Дүн	Хувь
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг		
Бүгд	**25 931**	**10 711.0**	**27 673**	**13 642.2**	**22 419**	**15 633.1**	**1 990.9**	**14.6**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	5 086	6 886.8	5 159	9 875.1	5 338	11 229.9	1 354.8	13.7
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 483	4 114.6	1 530	5 131.7	1 554	5 796.7	665.0	13.0
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 482	2 611.2	2 845	4 606.8	3 107	5 353.5	746.7	16.2
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	962	91.2	688	78.6	677	79.8	1.2	1.5
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 800	748.0	5 967	759.9	6 237	1 564.8	804.9	2.1[1]
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	5 514	477.4	6 875	427.8	1 778	391.1	- 36.8	- 8.6
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	11	2.2	27	4.6	11	3.1	- 1.5	- 32.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	560	156.9	883	205.2	723	159.4	- 45.8	- 22.3
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	5 706	1 939.7	5 071	1 832.6	4 440	1 712.0	- 120.6	- 6.6
Насны хишиг	3 254	500.0	3 691	537.0	3 892	572.9	35.9	6.7

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 677 хүн хамрагдсан нь өмнөх оноос 11 (1.6%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.
Эх үүсвэр: Нийгмийн даатгалын газрын нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын халамжийн сарын мэдээ

ЭРҮҮЛ МЭНД

2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 оны эхний 10 дугаар сард 693 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 126 (15.4%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 604 (87.2%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 29 (4.2%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Амаржсан эх	1 010	819	693	- 126	-15.4
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	979	769	632	- 137	-17.8
Гэрийн төрөлт	4	2	2	-	-
Амьд төрсөн хүүхэд	1 014	825	693	- 132	-16.0
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	968	753	604	- 149	-19.8
Төрөлхийн гажигтай төрсөн	6	9	3	- 6	-66.7
2500 граммаас доош жинтэй төрсөн	31	26	29	3	11.5
Амьгүй төрсөн хүүхэд	4	1	3	2	3.0 [1]
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	3.9	1.2	4.9	3.7	4.1 [1]

2025 оны эхний 10 дугаар сард нас баралтын 263 тохиолдол бүртгэгдсэний 22 (8.4%) нь осол гэмтлийн улмаас, 96 (36.5%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Нас баралт	248	284	263	-21	-7.4
Эмнэлгийн нас баралт	41	63	45	-18	-28.6
Эхийн эндэгдэл	-	1	-	-1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	47	40	22	-18	-45.0
Хорт хавдрын өвчлөл нас баралт	64	84	96	12	14.3
0-1 насны эндэгдэл	4	7	8	1	14.3
1-5 хүртэлх насны эндэгдэл	5	3	1	-2	-66.7

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 оны эхний 10 дугаар сард 693 болж, өмнөх оны мөн үеэс 161 (30.3%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар

Халдварт өвчин	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
	Хүн				
Бүгд	**817**	**532**	**693**	**161**	**30.3**
Вируст гепатит	4	1	1	-	-
Цусан суулга	28	13	16	3	23.1
Гахайн хавдар	2	1	-	- 1	-
Бруцеллёз	-	1	-	- 1	-
Салхинцэцэг	204	133	236	103	77.4
Энтервируст халдвар	107	83	5	- 78	-94.0
Улаан эсэргэнэ	14	-	2	2	-
Ecoli-оор/ A04.4/	-	14	1	- 13	-92.9
Ёлом	1	-	3	3	-
Салмонеллт	19	23	14	- 9	-39.1
Гар хөл амны өвчин	119	91	49	- 42	-46.2
Нярайн бактерт үржил	-	1	-	- 1	-
Хачигт	4	1	-	- 1	-
Халдварт эритема /B08.3/	-	-	36	36	-
Сүрьеэ	52	47	42	- 5	-10.6
Тэмбүү	29	31	63	32	2.0 [1]
Заг	41	60	67	7	11.7
Трихомониаз	50	32	25	- 7	-21.9
Ковид-19	143	-	-	-	-
Улаанбурхан	-	-	132	132	-
Менингококкт	-	-	1	1	-

Халдварт өвчний тохиолдлуудаас салхинцэцгээр 103 (77.4%)-аар, заг хүйтнээр өвчлөгчид 7 (11.7%)-өөр, цусан суулгаар өвчлөгчид 3 (23.1%)-аар тэмбүү 32 (2.0 дахин)-оор нэмэгдсэн нь өндөр өсөлттэй байна.

Шинээр халдварт улаан бурхан өвчний 132, менингококкт 1 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар 233.2 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 (0.7%) мянган хүнээр өсөж, 12.4 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 60.8 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 11.8 (24.1%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 12.6 мянган удаа гарсны 1.7 (13.5%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 882 (33.6%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 152 (36.3%)-аар өссөн байна.

2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар 571 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 18 хүн нас барж, 122 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2.0 тэрбум төгрөгийн хохирол учирсны 40.7 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 339 хүн холбогдон сэжиглэгдсэний 190 (44.0%) хүн нь согтуугаар, 18 (5.3%) хүн нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2025 оны эхний 10 дугаар сарын байдлаар нийт 41 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 208 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 571 гэмт хэргээс, илрүүлэлт 51.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.3 нэгжээр өссөн байна.

ЗУРАГ 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ ЗӨЭЛ

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны оны 10 дугаар сарын эцэст 3.3 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.

2025 оны 10 дугаар сарын эцэст Сүхбаатар аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 334.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 2.0 (0.6%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 29.6 (9.7%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 170.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 0.7 (0.4%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 4.7 (2.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт хадгаламжийн 86.5 хувь нь хугацаатай, 13.5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ЗУРАГ 6. ЗӨЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг

Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар буурчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2025 оны эхний 10 дугаар сард 75.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.9 (4.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Төсвийн зарлага санхүүжилт 74.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 17.1 (29.8%) тэрбум төгрөгөөр өсжээ.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 53.0 хувийг орон нутгийн төсвийн орлого, 14.8 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 9.7 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 17.8 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 0.1 хувийг урьд оны үлдэгдэл, 4.7 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.4 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 10 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 7.1 хувь, өмнөх оны эцсээс 4.2 хувь, өмнөх сараас 0.4 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. **ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар**



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.9 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 16.5 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 4.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 6.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 4.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.6 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр

ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2025 оны 10 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2025 X / 2024 X	2025 X / 2024 XII	2025 X / 2025 IX
	хувь		
Ерөнхий индекс	**7.1**	**4.2**	**0.4**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	7.9	6.0	0.6
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	3.1	2.4	0.1
Хувцас, бөс бараа, гутал	13.4	4.7	0.4
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	5.4	0.7	-0.5
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	1.9	1.6	0.2
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.0	2.6	0.9
Тээвэр	3.0	3.0	0.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	1.3	1.3	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	0.5	-0.4	0.0
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	16.5	12.1	1.3
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	65.0	65.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	9.0	9.0	0.1

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурахад хонь, ямааны мах 3.4 хувь, адууны мах 0.8 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хязаалан гунан үхрийн үнэ Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 10 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад соёолон үрээний үнэ 1.2 сая төгрөг болж, 216.6 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 2.4 сая төгрөг болж, 750.8 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 318.5 мянган төгрөг болж, 83.1 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 212.1 мянган төгрөг болж, 56.3 мянган төгрөгөөр тус тус өсөж, атны үнэ 1.2 сая төгрөг болж, 12.5 мянган төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 6. **НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард**

Төрөл	2022 Х	2023 Х	2024 Х	2025 Х	Өөрчлөлт	
	мян.төг				Дүн	Хувь
Нас гүйцсэн ат	1 200.0	1 212.5	1 187.5	1 175.0	-12.5	-1.1
Соёолон үрээ	945.8	1 054.5	991.7	1 208.3	216.6	21.8
Хязаалан гуна	1 450.0	1 540.0	1 690.9	2 441.7	750.8	44.4
Эр хонь	197.5	206.7	235.4	318.5	83.1	35.3
Эр ямаа	134.6	131.7	155.8	212.1	56.3	36.1

Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 10 дугаар сард Мөнххаан суманд хамгийн өндөр буюу 2.9 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 1.8 сая төгрөг байна.

ЗУРАГ 10. **НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 10 дугаар сард, мянган төгрөгөөр**



Хивэгний үнэ 2025 оны 10 дугаар сард 26.5 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 (15.9%) мянган төгрөгөөр, боодолтой өвсний дундаж үнэ 7.5 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.7 (8.0%) мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 11. **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 10 дугаар сард, төгрөгөөр**



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

ГАЗАР ТАРИАЛАН

Хураасан хүнсний ногоо өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өслөө.

Сүхбаатар аймгийн хэмжээнд ургац хураалтын явцын мэдээгээр 2025 оны 10 дугаар сарын байдлаар төмс 433.3 тонн, хүнсний ногоо 568.7 тонн, үр тариа 2.8 мянган тонн, тэжээлийн ургамал 1.7 мянган тонн, техникийн ургамал 943.0 тонн бэлтгэсэн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураасан хүнсний ногоо 7.0 (1.2%) тонн, үр тариа 403.0 (16.8%) тонноор тус тус өсөж, техникийн ургамал 177.0 (15.8%) тонн, төмс 96.0 (18.1%) тонн, тэжээлийн ургамал 1.0 (37.6%) мянган тонноор тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 11. ХУРААСАН УРГАЦ, тн

Төрөл	Жил			Сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2023 I-X	2024 I-X	2025 I-X	Дүн	Хувь
	тонн							
Үр тариа	3 478.0	2 865.0	2 395.0	2 535.0	2 395.0	2 798.0	403.0	16.8
Төмс	585.8	612.7	531.9	609.4	529.3	433.3	- 96.0	- 18.1
Хүнсний ногоо	872.2	1 060.6	569.2	1 034.9	561.7	568.7	7.0	1.2
Тэжээлийн ургамал	1 768.0	2 407.5	2 987.5	2 343.5	2 742.5	1 710.5	-1 032.0	-37.6
Техникийн ургамал	810.0	645.0	1 120.0	645.0	1 120.0	943.0	- 177.0	- 15.8
Бэлтгэсэн өвс	18 132.8	33 736.1	37 321.3	15 532.3	14 093.2	15 526.8	1 433.6	10.2

ЗУРАГ 23. ХУРААСАН ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



Нийт хураасан ургац нь тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 61.3 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 380.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 144.4 (61.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 144.3 (71.0%) тэрбум төгрөг, усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх салбар 1.6 (23.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 8. **АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар**

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-X	2025* I-X	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	**221 266.6**	**301 412.6**	**235 583.5**	**379 962.3**	**144 378.8**	**61.3**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	181 814.1	262 956.9	203 335.5	347 643.4	144 307.9	71.0
Боловсруулах аж үйлдвэр	29 791.3	26 755.2	23 427.8	21 986.7	-1 441.1	- 6.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 005.5	2 821.4	1 986.1	1 894.8	- 91.3	- 4.6
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	7 655.6	8 879.1	6 834.1	8 437.4	1 603.3	23.5

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 347.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 144.3 (71.0%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрсний олборлолт 99.3 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 14. **АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг**



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал, хайлуур жонш, хайрга, шороо 51.8 хувиас 58.7 дахин өсжээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт бялуу, хэрчсэн гурил, адуу, үхэр, ямааны мах, цэвэр ус, бетон зуурмаг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.1 хувиас 6.8 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 9. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2024 X	2024 I-X	2025* X	2025* I-X	өөрчлөлт	
		тоо				дүн	хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр							
Хүрэн нүүрс	мян.т	449.0	1 984.9	433.3	3 013.7	1 028.8	51.8
Цайрын баяжмал	мян.т	5.4	61.4	5.7	52.9	-8.5	-13.8
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	3.6	17.5	211.2	207.6	58.7 [1]
Хайлуур жонш	мян.т	3.0	14.8	2.3	24.5	9.7	65.5
Хайлуур жоншны баяжмал	мян.т	4.5	29.1	-	25.5	-3.6	-12.4
Хайрга, шороо	мян.м3	0.3	0.7	3.5	4.7	4.0	6.7 [1]
Боловсруулах аж үйлдвэр							
Талх	т	14.0	131.1	13.7	124.2	-6.9	-5.3
Нарийн боов	т	2.3	35.5	2.2	26.9	-8.6	-24.2
Хэвийн боов	т	1.1	22.8	0.5	14.9	-7.9	-34.6
Бялуу	т	0.3	3.0	0.7	3.9	0.9	30.0
Хэрчсэн гурил	т	0.0	0.4	0.3	1.6	1.2	4.0 [1]
Малын мах	т	550.8	2 316.2	526.6	2 188.2	-128.0	-5.5
Цэвэр ус	мян.л	84.0	687.2	78.3	694.7	7.5	1.1
Бууз, банш	т	1.3	12.8	0.7	5.1	-7.7	-60.2
Бусад төрлийн бэлтгэсэн хоол, хүнс	т	0.2	9.1	0.1	2.0	-7.1	-78.0
Хуванцар хүрээтэй хаалга, цонх	м2	94.0	440.0	-	123.0	-317.0	-72.0
Бетон зуурмаг	м3	2 468	8 298	1 575	10 421	2 123	25.6

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жил бүрийн эхний 10 дугаар сарын байдлаар, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2025 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 481.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 116.5 (31.9%) тэрбум төгрөгөөр өслөө.

ХҮСНЭГТ 10. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Жил		Сар		Өөрчлөлт	
	2023	2024	2024 I-X	2025* I-X	Дүн	Хувь
	сая төгрөг					
Нийт дүн	**432 086.8**	**447 687.6**	**364 986.9**	**481 453.4**	**116 466.5**	**31.9**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	391 677.9	406 886.4	331 216.8	446 582.4	115 365.6	34.8
Боловсруулах аж үйлдвэр	29 697.8	27 053.5	23 334.9	22 379.3	- 955.6	- 4.1
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2 453.5	3 893.7	2 713.8	2 778.3	64.5	2.4
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	8 257.6	9 854.1	7 721.4	9 713.4	1 992.0	25.8

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 116.5 (31.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд хүрэн нүүрс олборлолт 97.1 (89.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



Гадаад зах зээлд 2025 оны эхний 10 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 445.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 438.9 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 46.5 хувийг нүүрс олборлолтын салбар, 43.9 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 9.6 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

2025 оны эхний 10 дугаар сарын гүйцэтгэлээр 51.1 сая.квт.цаг эрчим хүчийг дамжуулан авч, 12.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн байна.

Хувараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 10 дугаар сарын гүйцэтгэлээр 2.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 31.6 (1.6%) сая төгрөгөөр өслөө. Иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 53.6 хувийг хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 26.6 хувийг хувцас үйлдвэрлэл, 9.2 хувийг мужааны зориулалттай модон эдлэл үйлдвэрлэл, 10.6 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Хувараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нарийн боов, бялуу, хучлага, даавуун уут, тор, дээлнээс бусад монгол хувцас, ажлын хувцас, бэлтгэлийн хувцас, оёмол плате, майк, бомбор, малгай, өмд, гутал, гэрийн мод болон бусад хэрэгсэл, гар урлал, блок зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.1 хувиас 16.8 дахин өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

БАРИЛГА

Барилга угсралт, их засварын ажил өмнөх оны мөн үеэс 60.3 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр өсжээ.

Барилгын байгууллагууд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 98.0 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсний 21.6 (22.0%) тэрбум төгрөг нь орон сууцны барилга, 15.4 (23.3%) тэрбум төгрөг нь орон сууцны бус барилга, 51.2 (52.3%) тэрбум төгрөг нь инженерийн барилга байууламж, 2.3 (2.3%) тэрбум төгрөг нь их засварын ажил хийж гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 16. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, тэрбум төгрөг



СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

БҮЛЭГ

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:

	Ерөнхий тэмдэглэл	
	Үндсэн үзүүлэлтүүд	
I	Хүн ам	С.Мөнхбаяр
II	Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III	Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV	Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
V	Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI	Мөнгө, банк	Б.Сумъяа
VII	Орон нутгийн төсөв	С.Мөнхбаяр
VIII	Үнэ	Б.Сумъяа
IX	Хөдөө аж ахуй	О.Ундрах
X	Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
XI	Барилга	С.Мөнхбаяр
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	
	Хавсралт хүснэгтүүд	

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: Хэлтсийн ахлах мэргэжилтэн Э.Анхцэцэг

ХЯНАСАН: Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР
II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр
II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар
II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар
II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар
II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ
III.I НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД
IV.1 ЭРҮҮЛ МЭНД
IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар
IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ
V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ
V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар
V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД
V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК
VI.1 ЗӨЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО
VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА
VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар
VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ
VIII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС
VIII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ
VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗӨЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар

IX ГАЗАР ТАРИАЛАН
IX.I ТАРИАЛСАН ТАЛБАЙ, сумаар, га-р
IX.II ХУРААСАН УРГАЦ, сумаар, тн-оор

X АЖ ҮЙЛДВЭР
X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар
X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар
X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр
X.6 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ

X.7 ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

XI. БАРИЛГА

XI.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ
XI.2 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, барилгын төрлөөр
XI.3 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, сумаар

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	X	XII	X	XII	X	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	**96**	**302**	**165**	**234**	**232**	**67**	**40.6**
Асгат	4	2	3	12	28	25	9.3 [1]
Баяндэлгэр	1	8	1	1	-	-1	-
Дарьганга	3	3	1	2	3	2	3.0 [1]
Мөнххаан	8	83	1	21	1	-	-
Наран	4	4	2	5	3	1	50.0
Онгон	5	2	2	2	2	-	-
Сүхбаатар	10	7	1	1	8	7	8.0 [1]
Түвшинширээ	2	3	2	15	14	12	7.0 [1]
Түмэнцогт	3	2	1	16	3	2	3.0 [1]
Уулбаян	-	26	4	2	2	-2	-50.0
Халзан	-	-	-	8	6	6	-
Эрдэнэцагаан	3	33	-	-	3	3	-
Баруун-Урт	53	129	147	149	159	12	8.2

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
	тоо															
Нийт дүн	**232**	**102**	**-**	**33**	**7**	**12**	**103**	**58**	**14**	**5**	**13**	**64**	**86**	**52**	**16**	**1**
Асгат	28	16	-	2	-	2	3	14	4	3	1	6	11	7	3	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	3	-	-	1	-	-	2	-	-	-	-	1	2	-	-	-
Мөнххаан	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-
Наран	3	-	-	-	-	1	2	-	-	-	1	-	1	1	-	-
Онгон	2	1	-	1	-	-	1	-	-	-	-	1	1	-	-	-
Сүхбаатар	8	4	-	3	-	-	2	3	-	-	2	3	2	1	-	-
Түвшинширээ	14	6	-	1	-	-	3	6	4	-	1	5	2	5	1	-
Түмэнцогт	3	2	-	3	-	-	-	-	-	-	1	2	-	-	-	-
Уулбаян	2	-	-	-	-	1	1	-	-	-	-	1	1	-	-	-
Халзан	6	1	-	1	-	-	3	2	-	-	-	1	1	3	1	-
Эрдэнэцагаан	3	1	-	2	-	1	-	-	-	-	-	-	2	1	-	-
Баруун-Урт	159	71	-	19	7	7	86	32	6	2	7	43	63	34	11	1

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-X	I-XII	I-X	I-XII	I-X	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	**1 264**	**1 870**	**1 309**	**1 874**	**1 383**	**74**	**5.7**
Асгат	60	70	73	159	71	-2	-2.7
Баяндэлгэр	7	33	1	62	1	-	-
Дарьганга	85	96	127	138	31	-96	-75.6
Мөнххаан	13	96	55	87	27	-28	-50.9
Наран	72	76	67	79	43	-24	-35.8
Онгон	85	135	16	85	32	16	2.0 [1]
Сүхбаатар	65	106	50	51	100	50	2.0 [1]
Түвшинширээ	180	184	65	165	144	79	2.2 [1]
Түмэнцогт	23	44	24	76	14	-10	-41.7
Уулбаян	40	88	20	32	25	5	25.0
Халзан	22	31	10	26	33	23	3.3 [1]
Эрдэнэцагаан	91	171	72	72	29	-43	-59.7
Баруун-Урт	521	740	729	842	833	104	14.3

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2023		2024		2025	өөрчлөлт	
	I-X	I-XII	I-X	I-XII	I-X	дүн	хувь
	тоо						
Нийт дүн	**409**	**764**	**596**	**1 022**	**669**	**73**	**12.2**
Асгат	51	62	45	120	38	-7	-15.6
Баяндэлгэр	3	22	-	60	-	-	-
Дарьганга	63	73	123	133	24	-99	-80.5
Мөнххаан	1	9	68	79	23	-45	-66.2
Наран	32	35	47	55	33	-14	-29.8
Онгон	47	97	14	83	25	11	78.6
Сүхбаатар	2	43	4	4	46	42	11.5 [1]
Түвшинширээ	47	48	39	126	85	46	2.2 [1]
Түмэнцогт	13	32	14	51	4	-10	-71.4
Уулбаян	22	44	10	21	9	-1	-10.0
Халзан	22	31	10	18	22	12	2.2 [1]
Эрдэнэцагаан	66	114	41	41	4	-37	-90.2
Баруун-Урт	40	154	181	231	356	175	96.7

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, сумаар

	2023 I-X				2024 I-X				2025 I-X				өөрчлөлт	
	Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс			Бүгд	Үүнээс				
		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал		Байнгын	Түр	Улирал	дүн	хувь
	тоо													
Нийт дүн	**854**	**548**	**284**	**22**	**476**	**233**	**230**	**13**	**579**	**271**	**277**	**31**	**103**	**21.6**
Асгат	65	29	36	-	45	10	35	-	34	7	27	-	-11	-24.4
Баяндэлгэр	25	10	15	-	-	-	-	-	37	8	29	-	37	-
Дарьганга	139	96	43	-	118	73	43	2	27	9	18	-	-91	-77.1
Мөнххаан	44	22	17	5	52	52	-	-	10	10	-	-	-42	-80.8
Наран	80	33	40	7	32	10	22	-	22	9	13	-	-10	-31.3
Онгон	15	11	4	-	13	13	-	-	11	3	8	-	-2	-15.4
Сүхбаатар	13	13	-	-	3	3	-	-	9	-	9	-	6	3.0[1]
Түвшинширээ	91	53	33	5	51	20	28	3	66	37	19	10	15	29.4
Түмэнцогт	27	27	-	-	18	18	-	-	-	-	-	-	-18	-
Уулбаян	37	15	22	-	24	1	20	3	29	17	7	5	5	20.8
Халзан	15	11	2	2	73	-	73	-	17	8	9	-	-56	-76.7
Эрдэнэцагаан	180	131	46	3	19	18	-	1	27	9	18	-	8	42.1
Баруун-Урт	123	97	26	-	28	15	9	4	290	154	120	16	262	10.4[1]

II.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	2025 I-X		Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар															
	Бүгд	Эмэгтэй	Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас агнуур	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэдээлэл, холбоо	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон технологийн үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй
	тоо																	
Нийт дүн	**579**	**280**	**84**	**54**	**2**	**22**	**40**	**5**	**24**	**6**	**2**	**259**	**3**	**7**	**22**	**8**	**40**
Асгат	34	15	13	-	-	3	2	-	-	-	-	11	-	2	-	-	6
Баяндэлгэр	37	23	-	-	-	-	-	-	-	-	-	29	-	-	-	-	-
Дарьганга	27	17	1	-	-	-	-	-	-	-	-	26	-	-	-	-	6
Мөнххаан	10	6	6	-	-	-	-	-	-	-	-	4	-	-	-	-	-
Наран	22	10	-	3	-	4	-	1	-	1	-	11	-	-	1	1	2
Онгон	11	5	-	-	1	-	-	-	-	-	-	1	1	1	4	3	5
Сүхбаатар	9	5	-	-	-	-	-	-	-	-	-	9	-	-	-	-	-
Түвшинширээ	66	26	15	20	-	-	-	-	-	-	-	27	2	-	-	-	8
Түмэнцогт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Уулбаян	29	11	11	-	-	-	6	-	-	-	-	10	-	-	-	-	3
Халзан	17	10	-	-	-	-	-	-	17	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	27	15	-	1	-	-	-	-	-	-	-	26	-	-	-	-	2
Баруун-Урт	290	137	38	30	1	15	32	4	7	5	2	105	-	4	17	4	8

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.I НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 483**	**4 114.6**	**1 530**	**5 131.7**	**1 554**	**5 796.7**	**665.0**	**13.0**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**2 482**	**2 611.2**	**2 845**	**4 606.8**	**3 107**	**5 353.5**	**746.7**	**16.2**
Асаргааны тэтгэмж	**1 259**	**1 752.1**	**1 451**	**3 550.2**	**1 557**	**4 157.0**	**606.8**	**17.1**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	212	300.3	248	618.6	267	717.0	98.3	15.9
Байнгын асаргаа шаардлагтай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	757	974.2	885	2 113.1	968	2 465.4	352.3	16.7
Байнгын асаргаа шаардлагтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	248	412.6	278	688.6	279	838.5	149.9	21.8
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	19	28.3	16	58.2	18	61.8	3.6	6.2
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	14.7	8	28.6	6	24.7	- 3.9	- 13.6
Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	16	22.0	16	43.0	19	49.6	6.6	15.3
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	**1 223**	**859.1**	**1 394**	**1 056.6**	**1 550**	**1 196.5**	**139.9**	**13.2**
Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн	933	137.9	1 082	164.2	1 236	188.6	24.4	14.9
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	257	681.6	273	845.7	279	965.9	120.2	14.2
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	2.4	3	3.6	1	1.2	-	-
Гэнэтийн аюулын улмаас орон гэргүй болсон өрхөд 1 удаа олгох тэтгэмж	29	34.8	36	43.2	34	40.8	- 2.4	- 5.6
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр орондгүй иргэн	2	2.4	-	-	-	-	-	-
Нийгмийн халамжийн үйлчилгээ	**159**	**69.8**	**96**	**58.1**	-	-	**- 58.1**	**-**
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	159	69.8	96	58.1	-	-	- 58.1	-
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	**962**	**91.2**	**688**	**78.6**	**677**	**79.8**	**1.2**	**1.5**
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	962	91.2	688	78.6	677	79.8	1.2	1.5
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	**5 800**	**748.0**	**5 967**	**759.9**	**6 237**	**1 564.8**	**804.9**	**2.1**[1]
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	**5 514**	**477.4**	**6 875**	**427.8**	**1 778**	**391.1**	**- 36.8**	**- 8.6**
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	**11**	**2.2**	**27**	**4.6**	**11**	**3.1**	**- 1.5**	**- 32.6**
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	**560**	**156.9**	**883**	**205.2**	**723**	**159.4**	**- 45.8**	**- 22.3**
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	**5 706**	**1 939.7**	**5 071**	**1 832.6**	**4 440**	**1 712.0**	**- 120.6**	**- 6.6**
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	4 019	1 494.2	3 640	1 382.3	3 174	1 244.7	- 137.6	- 10.0
Жирэмсэн эхийн тэтгэмж	1 532	203.8	1 273	168.3	1 106	138.7	- 29.6	- 17.6
Ихэр хүүхдийн тэтгэмж	8	16.0	7	14.0	8	16.0	2.0	60.0
